


ЗУГААТАЙ ЗОГСООЛ



РАЙН СТОКЕР

ХРИСТЭЭР ДАМЖУУЛАН БҮГДИЙГ

Энэ жилийн өсвөр үеийнхний уриа нь Филиппой 4:13: "Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна" хэмээх судар юм. Чиний хувьд энэ судар ямар утга учиртай болохыг бидэнд хэлж өгөөрэй. Чи Христээр дамжуулан бүгдийг хэрхэн хийж чадах вэ? Дараагийн дугаарын нийтлэлд өөрийн түүхийг хуваалцахыг хүсвэл ftsoy@churchofjesuschrist.org хаяг руу сэтгэгдэл, зургаа илгээнэ үү!



ШИНЭ ГЭРЭЭНИЙ УНШИГЧДЫГ БҮГДИЙГ НЬ ДУУДАЖ БАЙНА!

Бид энэ жил Шинэ Гэрээнээс суралцаж байгаа. Чи Шинэ Гэрээг гарын таван хуруу шигээ мэдэх үү? Эсвэл нэг азтай таагч уу? Чамайг Шинэ Гэрээний 27 номын хэдийг нь зөв дэс дарааллаар байрлуулж чадахыг (сэм харалгүйгээр!) чинь харъя. Чи 10-аас илүүг зөв тааж чадвал хожно! Чамд туслах цөөн хэдэн сэжүүр гаргаж өгье. (Мөн хэрэв чи сайн хийж чадаагүй бол, үүнийг гартаа оруултал бүтэн жилийн хугацаа байгаа шүү.)

- ___ Филиппой
- ___ Галат
- ___ Еврей
- ___ Марк. Сэжүүр: Сайн мэдээнүүдийн нэг (эхлэл хэсэгт байдаг).
- ___ Лук. Сэжүүр: Сайн мэдээнүүдийн нэг (эхлэл хэсэгт байдаг).
- ___ Иуда
- ___ 2 Тесалоник
- ___ 1 Петр
- ___ Матай. Сэжүүр: Сайн мэдээнүүдийн нэг (эхлэл хэсэгт байдаг).
- ___ 2 Петр
- ___ 1 Иохан. Сэжүүр: Иохан, 2 Иохан, 3 Иохантай андуурч болохгүй.

ЗҮРГИЙГ ЖОШ ТАЛБОТ

- ___ Үйлс. Сэжүүр: Сайн мэдээнүүдийн яг дараах Үйлс номыг харна уу.
- ___ Ефес
- ___ 2 Коринт
- ___ Тит
- ___ Иохан. Сэжүүр: Сайн мэдээнүүдийн нэг (эхлэл хэсэгт байдаг).
- ___ Иаков
- ___ Филемон Сэжүүр: Тоол. Энэ нь зөв газартаа байна.
- ___ Ром
- ___ 1 Коринт
- ___ 2 Тимот
- ___ 3 Иохан
- ___ 1 Тесалоник
- ___ Илчлэл. Сэжүүр: Эдгээр илчлэлтийн олон нь дэлхийн ТӨГСГӨЛийн тухай байдаг (мөн өөр нэг зүйлийн төгсгөл ч байж болох юм).
- ___ Колоссай
- ___ 1 Тимот
- ___ 2 Иохан



ГЭРЛЭЭР БУДАХ

Есүс Христ бол дэлхийн гэрэл мөн. Өнгө өнгийн гэрэл хэрхэн холилддогийг олж мэдэцгээе.

Будгаар будах үед үндсэн өнгөнүүд нь улаан, шар, цэнхэр өнгө байдаг. Гэрлийн үндсэн өнгөнүүд нь улаан, ногоон, цэнхэр юм. Гэрлүүдийг холих нь таны бодож байгаагаас өөр өнгийг гаргадаг. Гэрлүүдийн хослол ямар өнгө гаргахыг та нар тааж чадах уу?

Дараах өнгөнүүдээс сонгоорой.

